



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
ТОГТООЛ

1968 оны 6 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын ардын депутатуудын
хурлын гүйцэтгэх захиргааны зохион
байгуулалт, орон тооны тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх
захиргааны зохион байгуулалтыг дор дурьдсан газар, хэлтэс,
комисс, товчоодтой байхаар батласугай:

- а/зохион зааварлах хэлтэс;
- б/төлөвлөгөөний комисс;
- в/санхүүгийн хэлтэс;
- г/ардын боловсролын хэлтэс;
- д/соёлын хэлтэс;
- е/цэргийн хэлтэс;
- ж/их барилгын хэлтэс;
- з/ах ахуйн хэлтэс;
- и/хөдөлмөр, цалин хөлсний товчоо;
- к/архитектурын газар;
- л/статистикийн товчоо;
- м/иргэний хамгаалалтын штаб;
- н/эрүүлийг хамгаалах газар.

2. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх
✓ захиргааны орон тоог 17 нэгжээр хасаж, ерхийн төсвийн ста-
тистикч 8-ыг Статистикийн төв газарт шилжүүлэн, хавсралтын
ёсоор 88 нэгжээр тогтоосугай.

3. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зөвхөн байгуулалт, орон тооны тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 190 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тосвотой.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
нэгдүгээр орлогч дарга ЛУВСАН

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг Эрхлэх Газрын дарга БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн

эрхлэгчийг

Усан

/НАБИЙ/





СЭИД нарын Зөвлөлийн 1968 оны
185 дугаар тогтоолын хавсралт

Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын
гүйцэтгэх захиргааны орон тоо

№:	Албан тушаал	Орон тоо
1.	Дарга	1
2.	Орлогч дарга	4
3.	Хариуцлагатай нарийн бичгийн дарга	1
4.	Газар, товчоо, хэлтсийн дарга	9
5.	Иргэний хамгаалалтын штабын дарга	1
6.	Комисс, газрын орлогч дарга	2
7.	Байцаагч, зааварлагч, мэргэжилтэн, статистикч	45
8.	Даргын ба ШБОС-ын нарийн бичгийн дарга	2
9.	Боловсон хүчний эрхлэгч	1
10.	Бичиг хэргийн эрхлэгч	1
11.	Бичээч	3
12.	Архивын эрхлэгч	2
13.	Архивын фондоч	1
14.	Ерөнхий нябо	1
15.	Төсөв, хөрөнгө оруулалтын нягтлан бодогч	3
16.	Цэргийн хэлтэс, иргэний хамгаалалтын туслах	4
17.	Барилгын техникч	2
18.	Комендант, нярав	1
19.	Туслах ажилчин	2
20.	Оператор-бичээч	1
21.	Бичээч, бичиг хэрэг хөтлөгч	1
БИГД		88